

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2020 оны 04-р сарын 09-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн уурхайг Цогтцэций сумын төвтэй холбох 13.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ
Тендер шалгаруулалтын дугаар: ЭТТ/202001177

1. **Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхайг Цогтцэций сумын төвтэй холбох 13.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавих** зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн уурхайг Цогтцэций сумын төвтэй холбох 13.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд техник, технологийн хяналт тавихад оршино. Барилгын ажлыг 2020 оны 5 дугаар сараас 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хооронд авто замын барилга барих боломжтой улирлуудад багтаан дуусгахаар төлөвлөж байгаа.**

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

1. Тендерт оролцох сонирхлоо илэрхийлсэн болон уг хуулийн **14.1-д** заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдсэн албан бичиг
2. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. **2.8.3.1** -Авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник, технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/
4. Байгууллагын танилцуулга;
5. Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/
6. Харъяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тухай Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/
7. Иргэний хэргийн шүүхээс /Шүүхийн төрөлжсөн архив/ сүүлийн 3 жилийн байдлаар иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх талаарх тодорхойлолт Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/
8. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/
9. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан
10. Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын хоёроос доошгүй жилүүдэд ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болохыг тодорхойлсон **гэрээ, гэрээ дүгнэсэн акт** эсвэл үйлчлүүлэгчийн тодорхойлолт;
11. Хяналтын багт ажиллах голлох мэргэжилтнүүдийн танилцуулга, боловсролын зэргийн диплом, хяналтын инженерүүдийн хувьд хяналтын инженерийн итгэмжлэл, НД-8 маягт (сүүлийн 2 сарын буюу 2020 оны 1, 2 дугаар сарын)

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 04-р сарын 17-ны 17:00 цагийн** хооронд авч болно.

5. Мэдүүлгээ **2020 оны 4-р сарын 20-ны 10:00** цагийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ үү.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК
Жигжиджав-8, Финанс төв, 5 давхар
Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо
Улаанбаатар хот,
Утас: 7505-5555 дотуур утас-507